


МОНГОЛЫН
ИТГЭМЖЛЭЛИЙ
Н ТОГТОЛЦОО

БАТЛАВ
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗРЫН ДЭД ДАРГА

Б.БИЛГҮҮН

ISO 22000:2018 стандартын шилжилтийн бодлого

Боловсруулсан:	Хянасан:
	
Д.Удвал	С.Соронзонболд

ЦАХИМ ХУВЬ, ХЭВЛЭМЭЛ ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ БОЛНО.

ХЭВЛЭСЭН ОГНОО: 15.03.2019

ӨӨРЧЛӨЛТ NO: 00
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО:

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	Өөрчлөлт No	Хуудас No	Өөрчлөлтийн шалтгаан
1			

МОНГОЛЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ТОГТОЛЦОО		
Баримт бичгийн No: MNAS AP	ISO 22000:2018 стандартын шилжилтийн бодлого	
Хэвлэсэн огноо: 15.03.2019	Өөрчлөлт No:	хуудас No: 2/4
	Өөрчлөлтийн огноо:	

ISO 22000:2018 СТАНДАРТЫН ШИЛЖИЛТИЙН БОДЛОГО

2017 оны 10-р сард Ванкувер хотод болсон Олон улсын итгэмжлэлийн форум (IAF)-ын Ерөнхий ассемблейгаар ISO 22000:2018 стандартыг хэвлэгдсэн өдрөөс эхлэн шилжилтийн хугацааг 3 жил байхаар IAF-ийн 20137-16-р шийдвэрийг баталсан.

Шинэчлэгдсэн ISO 22000:2018 Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-шаардлага стандарт нь Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-аас 2018 оны 6-р сарын..... албан ёсоор хэвлэгдсэн.

Энэхүү шинэчлэгдсэн стандартад шилжих шилжилтийн хугацаа нь 2021 оны 6-р сарын 29-ний өдрөөр дуусгавар болно.

IAF-аас гаргасан шийдвэрийг үндэслэн Итгэмжлэлийн байгууллага /MNAS/-аас ISO 22000:2005 ба ISO 22000:2018 стандартын аль ч хувилбараар итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын гэрчилгээг шилжилтийн хугацаа дуусах хүртэл ижил тэнцүү хүлээн зөвшөөрөхийг мэдэгдэж байна.

Шинэчлэгдсэн стандартын талаар Итгэмжлэлийн байгууллага /MNAS/-аас баримтлах бодлогыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. MNAS-аар итгэмжлэгдсэн/ өргөдөл гаргагч Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны баталгаажуулалтын байгууллагууд энэхүү бодлогыг 2019 оны 04-р сарын 01-нээс эхлэн дагаж мөрдөнө.
2. MNAS-аас ISO 22000:2005 стандартын дагуу олгосон итгэмжлэлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа 2021 оны 06-р сарын 28-ны өдрөөр дуусгавар болно..
3. Үндэсний хэмжээнд итгэмжлэгдсэн Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны баталгаажуулалтын байгууллагууд нь үйл ажиллагаандаа ISO 22000:2018 стандартыг 2021 оны 06 дүгээр сарын 29 гэхэд бүрэн нэвтрүүлсэн байна.
4. Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны баталгаажуулалтын байгууллага (ББ) нь ISO 22000 стандартын одоогийн болон шинэ хувилбарын хоорондын зөрүү (GAP)-г шинжилж, хүлээгдэж буй өөрчлөлтийн нөлөөлөл, шинэ стандартын дагуу баталгаажуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тодорхойлж, өөрчлөлтийг шийдвэрлэх шилжилтийн төлөвлөгөө боловсруулна. Үүнд.
 - a. Аудиторууд, бусад ажилтнуудын сургах, ур чадварыг баталгаажуулах;
 - b. ББ-ын үйлчлүүлэгчидтэй харилцах зохицуулалт;
 - c. ББ-ын шинэ стандартад нийцсэн аудит хийх зохицуулалт. Жишээлбэл, нэг удаагийн айлчлал уу эсвэл тодорхой үе шаттай арга хэмжээ байх уу.

МОНГОЛЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ТОГТОЛЦОО		
Баримт бичгийн No: MNAS AP	ISO 22000:2018 стандартын шилжилтийн бодлого	
Хэвлэсэн огноо: 15.03.2019	Өөрчлөлт No:	хуудас No: 3/4
	Өөрчлөлтийн огноо:	

- d. ББ нь шилжилтийн явцад үйлчлүүлэгчдийн ISO 22000:2018 стандартад нийцсэн байдлыг хэрхэн батлах вэ.
 - e. ISO 22000:2018 хэвлэгдсэнээс хойш 3 жилийн дотор шилжилтийг хийж чадаагүй үйлчлүүлэгчдэд холбогдох арга хэмжээ. Жишээлбэл, баталгаажуулалтыг сэргээхэд шаардлагатай аудитын түвшин.
5. ББ нь шилжилтийн төлөвлөгөөг 2020 оны 03 дугаар сарын 01-ний дотор Итгэмжлэлийн байгууллага /MNAS/-д ирүүлсэн байна.

Үнэлгээний явц:

1. MNAS нь 2019 оны 10-р сарын 01-нээс эхлэн ISO 22000:2005 стандартын хуучин хувилбараар өргөдөл хүлээж авахгүй.
2. Шинээр өргөдөл гаргагчийн бүх үнэлгээг (урьдчилсан үнэлгээ/анхдагч үнэлгээ) болон MNAS-аар итгэмжлэгдсэн хүнсний аюулгүй байдлын удирлагын тогтолцооны баталгаажуулалтын байгууллага (магадлах үнэлгээ/давтан үнэлгээ)-ын үнэлгээг хуваарийн дагуу 2019 оны 10-р сарын 01-ний өдрөөс эхлэн ISO 22000: 2018 стандартын дагуу хийнэ.
3. Хүнсний аюулгүй байдлын тогтолцооны баталгаажуулалтын байгууллагуудад ISO 22000:2005 стандартын дагуу итгэмжлэл олгохдоо 2020 оны 06-р сарын 25-ны өдрөөс эхлэн үнэлгээний хуваарийн дагуу ISO 22000:2018 стандартад нийцэж байгааг нотлох магадлах үнэлгээг 2021 оны 06-р сарын 29-ний өдрөөс өмнө гүйцэтгэнэ.
4. MNAS-аар итгэмжлэгдсэн Хүнсний аюулгүй байдлын тогтолцооны баталгаажуулалтын байгууллагууд нь ISO 22000:2018 стандартыг шаардлагыг 2021 оны 06-р сарын 28-ны өдөр гэхэд бүрэн хангасан байна.
5. Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны баталгаажуулалтын байгууллага нь ISO 22000:2018 стандартын шаардлагыг 2021 оны 06-р сарын 28-ны өдрийг хүртэл хангаж чадаагүй бол 03 сарын хугацаагаар итгэмжлэлийг түр түдгэлзүүлэх нөхцөлтэйгээр байлгана. Энэ хугацаанд ISO 22000:2018 стандартын шаардлагыг хангаагүй бол итгэмжлэлийг хүчингүй болгоно.

МОНГОЛЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ТОГТОЛЦОО		
Баримт бичгийн No: MNAS AP ...	ISO 22000:2018 стандартын шилжилтийн бодлого	
Хэвлэсэн огноо: 15.03.2019	Өөрчлөлт No:	хуудас No: 4/4
	Өөрчлөлтийн огноо:	